

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


## АГЕНТЛАГИЙН ДАРГА НАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 53 дугаар тэмдэглэлд:

“XIX.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2021 оны хагас жилийн дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав:

1. Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Албан даалгавар болон Ерөнхий сайдын захирамжаар Засгийн газар, сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан заалт бүрийг хяналтад авч, хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж ажиллах;
2. Үүрэг, даалгавар болгосон шийдвэрийн хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу тогтоосон хугацаанд “Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан” ([www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn))-д байршуулж, хяналт-шинжилгээ, үнэлгээг үнэн зөв, хийж, гарсан үр дүнг зохих журмын дагуу баталгаажуулж, эрх бүхий байгууллагад хүргүүлэн тайлагнаж байх;
3. 2021 оны хагас жилийн байдлаар хэрэгжилт нь удаашралтай, гүйцэтгэл нь хангалтгүй байгаа үүрэг, даалгаврын шалтгааныг тогтоон, хэрэгжилтийг эрчимжүүлэх, гүйцэтгэлийг сайжруулах;
4. Хууль тогтоомжийн дагуу хамтран батлах эрх зүйн акт (дүрэм, журам, заавар)-ыг тогтоосон хугацаанд нь батлан мөрдүүлж байх;
5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх явцад салбар, хоорондын уялдаа холбоог сайтар хангаж ажиллах.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР